



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/91

Улаан-Уул

Зам дагуу гэрэлтүүлгийн ажил
хүлээлцэх комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчит хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн зам дагуу гэрэлтүүлгийн ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга: Г.Нямдаваа (6 дугаар багийн Засаг дарга)

Гишүүдэд: Б.Ганболд (Гэрлийн моничёр)

Г.Очгэрэл (Сан хариуцсан нягтлан бодогч)

Б.Амарсанаа (Тамгын газрын нярав)

2.Зам дагуу гэрэлтүүлгийн ажлыг гэрээний дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянаж хүлээж авахыг комисс (Г.Нямдаваа)-д даалгасугай.

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАТ

642201175